

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 04-ний өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын




дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1, 68.4 дэх заалтууд болон Компанийн дүрэм, 2025 оны 04-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,530,145 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч, мөн хуралд биечлэн оролцож байгаа 24,939,509 саналын эрхтэй 19 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул тооллогын дүнг хавсралтын дагуу баталж, ээлжит хурлын дарга (Д.Оюунсүрэн)-д танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН



 Г.БААСАНСҮРЭН
 С.ОДОНЧИМЭГ
 Г.ОЮУНДАРЬ

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 04-ний өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Саналын хуудасны
нэгдсэн дүнгийн тухай

Тус компанийн 2025 оны 04-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны нэгдсэн дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Хэлэлцсэн 1-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрч, тогтоолыг батлав. (Хавсралт №01)

Хэлэлцсэн 2-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрч, тогтоолыг батлав. (Хавсралт №01)

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН



Г.БААСАНСҮРЭН

С.ОДОНЧИМЭГ

Г.ОЮУНДАРЬ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын
дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, Компанийн дүрэм, 2025 оны 04-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй 85.91 хувийн хувьцаа эзэмшигчид (хавсралт №1) оролцсон тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсугай.
2. Хурлын ирц хангалттай тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг үндэслэн “Гермес Центр” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 04-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хавсралтын дагуу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Гермес Центр” ХКомпани нь 2024 онд бүтэц зохион байгуулалтын хувьд 16 ажилтан ажиллагсадтайгаар батлагдсан төсөв төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Тус компанийн 2024 оны татварын дараах цэвэр ашиг 1.775,2 сая төгрөг байгаа бөгөөд энэхүү ашгийг төлөвлөгөө 1,595.1 сая төгрөг байсантай харьцуулахад 111%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 180.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Компанийн 2024 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 22 төгрөг 60 мөнгө байгаа бөгөөд ногдол ашгийн төлөвлөгөө 20 төг 31 мөнгө байсантай харьцуулахад 111%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 2 төг 29 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан байна.

Тиймээс гүйцэтгэх удирдлагын багийг 2024 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай сайн ажилласан хэмээн ТУЗ-өөс дүгнэж байна.

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2025 оны 04-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчийн 100 %-ийн саналаар хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Д.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Эрсдэл аудитын хороо (Д.Туяа)-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН